МОНГОЛ УЛС
ДОРНОД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 03 сарын 23 өдөр Дугаар А/180 Чойбалсан

Цэвэрлэгээ, халдваргүйжүүлэлтийн
ажил зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5 “а”, 29.1.6 “л”, Эрүүл мэндийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.4, Эрүүл ахуйн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.1, 11.1.4, 11.1.5, 11.1.6, 11.1.7, 11.1.8, Хог хаягдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3.10, 9.4.12, Мал амьтны эрүүл мэндийг хамгаалах тухай хуулийн 7 дугаар зйүлийн 7.3.2, 7.3.3, Улсын Онцгой комиссын 2020 оны 5 дугаар хуралдааны тэмдэглэлийн 9.3 дахь заалтыг үндэслэн тус тус ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Монгол Улсад Шинэ төрлийн коронавируст халдвар /COVID-19/-ын тохиолдол бүртгэгдсэнтэй холбогдуулан аймгийн хэмжээнд нийтийн эзэмшлийн талбай, гудамж, хүн ихээр зорчдог газар, барилга байгууламж, автобусны буудлуудад цэвэрлэгээ, халдваргүйжүүлэлт хийх ажлыг 2020 оны 03 дугаар сарын 25-ны өдрөөс 04 дүгээр сарын 05-ны өдрийг хүртэлх хугацаанд хийж гүйцэтгэхийг бүх төрийн болон орон нутгийн өмчит аж ахуйн нэгж байгууллага, сумын Засаг дарга нарт даалгасугай.

2.Жил бүрийн 04 дүгээр сарын 10-ны өдрөөс 05 дугаар сарын 10, 09 дүгээр сарын 10-ны өдрөөс 10 дугаар сарын 10-ны өдрийг хүртэлх хугацаанд өөрийн харьяалах нутаг дэвсгэрийн хэмжээнд хүн амын ундны усны эх үүсвэр, төвлөрсөн болон төвлөрсөн бус ариун цэврийн байгууламж, гэр хорооллын айл өрхүүдийн нүхэн жорлон, бохир усны цооног, орон сууцны барилгын орц, хонгил, зоорийн давхар, хог хаягдлын цэг, нийтийн эзэмшлийн зам, талбай, үйлчилгээний газар, аж ахуйн нэгж, байгууллагуудын дотоод, гадаад цэвэрлэгээ, халдваргүйжүүлэлтийг мэргэжлийн байгууллагуудын зөвлөмж, зааврын дагуу тусгай зөвшөөрөл бүхий ариутгал, халдваргүйтгэлийн аж ахуйн нэгжтэй хамтран чанартай зохион байгуулж ажиллахыг сумын Засаг дарга нар, “Чойбалсан хөгжил” Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар /Б.Тэгшжаргал/-т үүрэг болгосугай.

3.Тус ариутгал халдваргүйжүүлэлт, хог хаягдлыг зайлуулах ажилд мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлж ажиллахыг аймгийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг Мэргэжлийн хяналтын газар /Д.Мөнхтуяа/, Эрүүл мэндийн газар /Ч.Оюунаа/-т тус тус даалгасугай.

010120559

4.Аймгийн хэмжээнд хүн амын ундны усны эх үүсвэр, төвлөрсөн болон төвлөрсөн бус ариун цэврийн байгууламж, хог хаягдлын цэгийн судалгааг жил бүр шинэчлэн, “Нүхэн жорлон, угаадасны нүх MNS5924:2015” болон нийтийн үйлчилгээний байгууллагуудын холбогдох стандартуудын хэрэгжилтэд тавих хяналт, зөвлөн туслах ажлыг эрчимжүүлэхийг аймгийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг Мэргэжлийн хяналтын газар /Д.Мөнхтуяа/, Стандарт, хэмжил зүйн хэлтэс /Н.Энхболд/-т тус тус үүрэг болгосугай.

5.Хүн, малын халдварт өвчин тархахаас урьдчилан сэргийлэх зорилгоор зүй бусаар хорогдсон мал, амьтны сэг зэмийг цуглуулан булж устгах, бэлчээр, бууц, хашаа байр, уст цэг, булгийг цэвэрлэх, халдваргүйжүүлэх ажлыг жил бүрийн 04 дүгээр сард зохион байгуулахыг сумын Засаг дарга нарт, мэргэжил арга зүйгээр ханган дүн мэдээг нэгтгэж танилцуулахыг аймгийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг Байгаль орчин, аялал жуулчлалын газар /Б.Эрдэнэбаяр/, Мал эмнэлгийн газар /Ч.Аюушмаа/, ажлын гүйцэтгэлд хяналт тавьж ажиллахыг Мэргэжлийн хяналтын газар /Д.Мөнхтуяа/-т тус тус үүрэг болгосугай.

6.Цэвэрлэгээ, халдваргүйжүүлэлтэд шаардагдах бодис, хамгаалах хэрэгсэл, тоног төхөөрөмж, ажиллах хүчний зардлыг жил бүрийн төсөвт тусгаж батлуулахыг сумын Засаг дарга нар, “Чойбалсан хөгжил” Орон нутгийн өмчит, аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар /Б.Тэгшжаргал/, аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс /Х.Бат-Эрдэнэ/, Санхүү, төрийн сангийн хэлтэс /Н.Базаррагчаа/-т тус тус даалгасугай.

7.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, тайланг жил бүрийн 06 дугаар сарын 01, 11 дүгээр сарын 01-ний дотор аймгийн Засаг даргад танилцуулахыг аймгийн Засаг даргын орлогч /Ч.Ганбат/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА М.БАДАМСҮРЭН